



Цооногийн болон цэглэн дээжлэлтийн  
мэдээлэл цуглуулах, удирдах, хуваалцах  
ажлыг хялбарчлан та дэлхийн хаана ч  
байсан хурдан, оновчтой шийдвэр  
гаргахад тусална

MX Deposit нь төрөлдөө цорын ганц үүлэн системд (SaaS) суурилсан өгөгдлийн удирдлагын платформ ба уул уурхайн бүх үе шатанд шаардлагатай цооногийн болон цэглэн дээжлэлтэй ажиллах арга барилыг тань өөрчилнө. Тиймээс, та хайгуулын цооног, хээрийн дээжлэлт, агуулгын хяналтын өрөмдлөг, эсвэл байгаль орчны нөхөн сэргээлтийн дээжлэлт зэрэг ямар ч төрлийн өгөгдөлтэй ажилласан MX Deposit танд туслах болно.

## MX Deposit өртөг багатай, уян хатан шийдэл бүхий платформ

Бидний ажилд тулгардаг асуудлуудыг шийдэх уян хатан, ашиглалтын зардал багатай өгөгдлийн удирдлагын шийдлийг хаанаас олох вэ? гэсэн асуултад MX Deposit шийдэл олж өгөх болно.

### ХЯМД ҮНЭ


Та суурилуулалт, сургалт, эсвэл ашиглалтын зардал дээр санаа зовох шаардлагагүй боллоо. Үүлэн системийн давуу талуудыг шингээсэн MX Deposit системийг та хэрэгцээтэй үедээ төлбөрөө төлөн ашиглах боломжтой.

### УЯН ХАТАН ЧАНАР

MX Deposit нь таны үүсгэх төсөл, хадгалах өгөгдлийн тоо хэмжээг хязгаарлахгүй уян хатан чанартай тул хэрэглэгч таны хэрэгцээнд бүрэн нийцнэ.

### ЦАГ ХУГАЦААГ ХЭМНЭНЭ

MX Deposit нь өгөгдлийн удирдлагын шийдлийн бүх хэрэгцээг хангах ба тохиргоо хийхэд хэдхэн цаг л хангалттай. MX Deposit нь өгөгдөл цуглуулах явцыг автоматжуулж, бүх өгөгдлийг нэг газар төвлөрүүлдэг тул та болон таны баг файл дамжуулах эсвэл сүүлийн хувилбарыг хайх шаардлагагүй.



## MX Deposit нь хэрэглэгчдэд өөрсдийн төсөл, систем, оролцогч талуудыг үр дүнтэй удирдах, хянах боломжийг олгодог.

### ЧАНАРЫН ХЯНАЛТ

MX Deposit нь үйл ажиллагааны нарийвчилсан бүртгэлийг хөтлөөд зогсохгүй Чанарын баталгаа (ЧБ), чанарын хяналт (ЧХ)-ын чиглэлээр салбарын шилдэг туршлагыг баримталдаг систем юм.

### АЮУЛГҮЙ БАЙДАЛ

MX Deposit нь мэдээллийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж ажилладаг. Мөн өгөгдлийн өндөр түвшний хамгаалалтыг хангахын тулд бүтээгдэхүүн, платформ болон үйл ажиллагааны процессуудад дэвшилтэт, олон давхаргат хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн. Өгөгдлийн сангийн холболт, мессежийн дараалал, болон бусад HTTP холболтууд гэх зэрэг бүх бүрэлдэхүүн хэсгүүдийн холболтууд шифрлэгдсэн байдаг.

### ИЛ ТОД БАЙДАЛ

Хэрэв та олон төслийн, олон оролцогч талуудтай ажилладаг бол MX Deposit нь өгөгдөл болон түүнийг хэрхэн удирдан зохион байгуулж байгаа талаар хүн бүрт хэрэгтэй ил тод байдлаар хангадаг. Ил тод байдал нь хамтын ажиллагаанд нэн чухал ба төслийн амжилттай байх үндэс юм.

### ЗОХИЦОЛДОО

Манай API нь танд хүссэн үедээ холбогдох, дотоод мэдээлэл дээр үндэслэсэн шийдвэр гаргахад тусална. Түүнчлэн Leapfrog-той шууд холбогдож, динамик шинэчлэлүүдийг ашиглан тасралтгүй сайжруулах, оновчлох боломжтой.



Эдгээр залуус бол анхдагч мэдээллийг цуглуулдаг гол мэргэжилтнүүд юм. Хэрэв бид алдааг багасгаж, даалгавруудыг хялбарчилж, өгөгдөл оруулахтай холбоотой санаа зовнилыг бууруулснаар үйл явц нь илүү үр дүнтэй болж, дараагийн үе шатанд асуудал багатай болно.

—ОУЕН НИКОЛС, ХАЙГУУЛЫН МЕНЕЖЕР (АНУ), ЭКУИНОКС ГОУЛД /EQUINOX GOLD/

## Экүинокс Гоулд компани нь гурван өөр улсад өөрсдийн өрөмдлөгийн өгөгдлийг удирдан явуулж байна

MX Deposit нь өрөмдлөг, цэглэн дээжлэлтийн өгөгдөл цуглуулах, удирдах, хуваалцахад зориулан хийгдсэн өгөгдлийн удирдлагын платформ юм.

Экүинокс Гоулд компани нь 2023 оноос жилд нэг сая унц алт олборлохоор зорьж байна. Энэ нь тив даяар тархсан, уул овоо шиг олон өрөмдлөгийн өгөгдөлтэй Канадын залуу компанийн шийдвэр гаргагчдад тийм ч хялбар ажил байгаагүй юм.

Алт хэдий сайхан ч үнийн хувьд тогтворгүй. Түүхий эдийн үнэ, төслүүд өөрчлөгддөг тул тэдэнд өрөмдлөгийн мэдээллийг хүртээмжтэй, үнэн зөв, бүх үе шатанд зардал багатай байх уян хатан шийдэл хэрэгтэй болсон.

Үйл ажиллагаа тэлэхийн хэрээр хүснэгтэн файлууд, зөөврийн хатуу дискүүдийн багтаамж хязгаартаа тулсан байлаа. Тэдэнд илүү уян хатан шийдэл хэрэгтэй болсон. Бусад өгөгдөл цуглуулах шийдлүүдийн серверийг байгуулахад их хугацаа зарцуулагдахаас гадна өгөгдөл оруулах сургалтууд авах шаардлагатай байдаг. Гэвч Экүинокс гоулд-н байнга өөрчлөгдөж байдаг багуудын шинэ гишүүн бүрийг нарийн төвөгтэй программ хангамжид сургах цаг байдаггүй.

“

MX Deposit-н хэрэглэгчийн интерфэйс нь хангалттай ойлгомжтой ба маш хялбар тул сургалт заавал шаардагддаггүй. Цооногийн өгөгдөл оруулахад хялбар, бүх шаардлагатай зүйлсийг зориулаад хийчихсэн байдаг. Тиймээс та нээгээд л шууд бичиглэлээ хийж эхэлнэ.

–ОУЕН НИКОЛЛС, ХАЙГУУЛЫН МЕНЕЖЕР (АНУ), ЭКҮИНОКС ГОУЛД /EQUINOX GOLD/

Ялгаатай цагийн бүсэд ажилладаг геологуудаас файлын нэр асуун э-мэйл бичиж байхын оронд MX Deposit-г ашигласнаар өрөмдлөгийн сүүлийн мэдээллийг онлайнаар, төвлөрсөн эх нэг үүсвэрээс шууд татан авна.

Алт олборлолт нь ажлын циклээрээ алдартай салбар юм. Төслийн үе шат, зах зээлийн нөхцөлөөс үүдэн Экүинокс гоулд багуудыг томсгох, хумих үйлдлийг хурдтайгаар хийх шаардлага гардаг.


“

Энэ нь зардлыг хэмнэх бөгөөд уян хатан зардлыг таньд санал болгох юм. Та хээрийн ажлын үеэр зардлаа хялбарханаар нэмж, ажил дуусахад буцаагаад зардлаа хасах боломжтой юм.

–ВЕС ХОДСОН, ӨГӨГДЛИЙН МЕНЕЖЕР, ЭКҮИНОКС ГОУЛД

Зөвхөн 2019 онд 200,000 унц алт олборлох урьдчилсан тооцооноос авч үзвэл тэдний төслүүд өргөжих нь тодорхой ба MX Deposit тэдний хэрэгцээ шаардлагад бүрэн уялдах болно.

Хүдэр шиг анхаарал татам биш ч тодорхой, цэгцтэй мэдээлэл нь багийн шийдвэр гаргагчид болон менежерүүдэд үнэлж баршгүй зүйл юм.



# Үндсэн давуу талууд



|                                                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|-------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| ХЯЛБАР ТОХИРУУЛГА                                                 | Модуль, хэрэгслүүд, болон өгөгдлийн объектыг төслийн бүх хүрээнд ашиглахаар тохируулах боломжтой – үүнд хөрсний дээж цуглуулахаас эхлээд хайгуулын чөмгөн болон цохилтот өрөмдөг, агуулгын хяналтын өрөмдлөг, далд уурхайн дээжлэлт, овоолгын дээжлэлт, бутлуурын хэсгийн дээжлэлт болон бусад үйл ажиллагаанууд багтана.               |
| ЦООНОГИЙН БИЧИГЛЭЛ                                                | MX Deposit нь цооног болон дээжлэлтийн өгөгдөл оруулах орчны бүрэн хяналтыг танд өгдөг. Мобайл апп ашиглан хээрийн бичиглэлийг үр дүнтэй оруулах, баталгаажуулах давуу талуудыг ашиглаарай.                                                                                                                                             |
| ЗӨӨВРИЙН БОЛОН СҮЛЖЭЭГҮЙ ҮЕД ӨГӨГДӨЛ ОРУУЛАХ                      | Зөөврийн болон сүлжээгүй орчинд өгөгдөл оруулах нь хээрийн нөхцөлд уян хатан байдлаар ашиглах боломжийг олгодог. Андроид таблет апп ашиглан хаанаас ч онлайн болон оффлайн орчинд өгөгдөл оруулах, засварлах, эсвэл зөвхөн хянах боломжтой.                                                                                             |
| ИМПОРТ БА ЭКСПОРТ                                                 | Хамтран ажилладаг лабораторио холбосноор дээжийг шинжилгээнд илгээх, шинжилгээний хариуг хүлээн авна. Загварчлалын программаас өгөгдөл татах, оруулах боломжтой. ГМС-ээс цэглэн дээжийн мэдээлэл рүү шууд хандаарай. Бусад гуравдагч программ хангамжуудтай API ашиглан холбогдоно.                                                     |
| ДЭЭЖИЙГ ШИНЖИЛГЭЭНД ИЛГЭЭХ                                        | Дээжийг лабораторийн шинжилгээнд илгээх функцтэй. MX Deposit дээр дээжийн захиалгын ерөнхий мэдээлэл, үйлчилгээний үнэ, дээж бэлтгэлийн төрлүүд болон өргөн хэрэглэгддэг шинжилгээний төрлүүд бэлтгэгдсэн байдаг. Эдгээр бэлдцүүдээс өөрийн хэрэгцээнд тааруулан хялбар аргаар ашиглах боломжтой.                                       |
| ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖМЕНТ | Урьдчилан бэлдсэн, тохируулах боломжтой баталгаажуулалтын дүрмийг ашиглан өөрийн бүх өрмийн цооног болон дээжлэлтийн мэдээллийг импортлох, баталгаажуулах. Шинжилгээний үр дүн болон өгөгдлийн чанарын тайланг ЧБ/ЧХ ашиглан гаргана.                                                                                                   |
| ХӨРСНИЙ ДЭЭЖ                                                      | Хөрсний, гаршийн, бутлуурын, далд уурхайн хананы гэх мэт дээжлэлийн мэдээллийн оруулах, шалгах, хянах боломжтой.                                                                                                                                                                                                                        |
| ТӨСӨЛ БА АЖЛЫН УДИРДЛАГА                                          | Төсөл ба ажлын удирдлагын боломжуудыг урьдчилан бэлдсэн байдаг. Төслийн ерөнхий мэдээллийн хэсгээс төслийн явц, төслийн төлөв харахаас гадна тайлан хурдан бэлтгэх боломжтой. Өмнө нь бэлдсэн ажлын усргалыг ашиглан өгөгдөлтэй ажиллах, удирдах зэргийг нэг жишигт оруулна.                                                            |
| ХЯНАЛТЫН САМБАР                                                   | MX Deposit хяналтын самбар нь мэдээллийн аюулгүй байдлыг хангасан ба байгууллагын хэрэглэгчид бодит цагийн горимд өөр хүний оролцоогүйгээр тайлан авах боломжийг олгоно. Хаанаас ч, хэзээ ч системд нэвтрэн шаардлагатай тайлан мэдээллийг авах тул шийдвэр гаргахад дөхөм болох ба төслийг зөв чигт удирдан явуулах боломжоор хангана. |
| МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ, ХАМТРАН АЖИЛЛАХ                                | MX Deposit-н төвлөрсөн мэдээлэл солилцох хэсэг нь багийн гишүүдийн хамтын ажиллагааг сайжруулна. Хаана байршиж байгаагаас үл хамааран мэдээллийг цаг алдалгүй авна. Мэдээлэлтэй холбоотой асуулт, хариулт авах, сэтгэгдэл бичих боломжтой.                                                                                              |

MX Deposit танд тулгараад буй өгөгдлийн  
удирдлагын асуудлыг хэрхэн шийдэж чадах  
талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
бидэнтэй доорх хаягаар холбогдоорой.

[www.seequent.com/products-solutions/mx-deposit/demo/](http://www.seequent.com/products-solutions/mx-deposit/demo/)



Илүү сайхан ертөнцийг бүтээхийн  
тулд дэлхийгээ таньж мэдэх  
хэрэгтэй.

[seequent.com](http://seequent.com)

Seequent, The Bentley Subsurface Company